

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Хайдавгэлэгийн Чулуунбаатар	Дугаар	L053
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Булган сум
Төрсөн газар	Дорнод аймгийн Булган сум	Төрсөн он	1953
Ажил мэргэжил	"Туг"ХХК-ны захирал		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Тугийн сүм	Сүм хийдийн дугаар	ДОБГ 003
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 23	Ярилцлага авсан хүн	Ж. Одгарьд



Дорнод аймгийн Булган сум Тугийн сүм

Манай аймагт түүх дурсгалын хоёр том дурсгал байна. Бар хот байна. Хэрлэн Барс хот бол Киданы үеийн дурсгал. Тугийн сүм байна. 1923 онд Булган сум байгуулагдсан. Тэр үед бол Хэрлэн Барс хот манай сумын нутагт байсан. Сүүлдээ 40 хэдэн онд Цагаан-Овоо чинь урдаас Шиньжанаас орж ирсэн буриад. Тэгээд Хөлөнбуйр сум мөн урдаас орж ирсэн. Эд нарыг нааш нь татаж байрлуулахад Булган сумаас газар хуваарилаж өгөхөд Хэрлэн Бар хот бол Цагаан-Овооны нутагт ороод явчихсан юм. Хэрлэн Бар хот бол хоёр багана байсан. Миний багад байсан. Нэг нь туйпуу чулууг нь авсаар байгаад одоо юу ч үгүй болчихож.

-Та Тугийн сүмийн үүх түүхийн тухай юу мэдэх вэ? Таныг энэ тухай сонирхож судалдаг. Ном хамтарч бичсэн ч гэж сонслоо. Энэ тухайгаа сонирхуулаач?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тугийн сүмийг бол сүйтгэсэн тухайг нь сонсож байсан. Монголд Чингисийн тугийн хоёр сүм байсан. Нэг нь Баруун Монголд, нэг нь Зүүн Монголд. Нэг нь цагаан тугийн тахилгын сүм. Луу гүний хошуунд. Хар тугийн сүм манай нутагт. Булган сумд. Энэ тухай судлаачид хэлж, бичиж байсан. Б. Ринчен доктор бичиж байсан. Манайд байсан Тугийн сүмийн зураг Улсын төв музейд байдаг. Тэр зургаар ямархуу дуган байсан гэх зэргийг хэлж байгаа.

Шүтээний сүм дотроо Чингис хаан голдоо, 9 өрлөгтэйгээ байсан. 9 өрлөг нь сэлмээ сугалдаг. Нүд нь хөдөлдөг байжээ. Голд нь эзлэгдсэн улсуудын хүмүүс Чингис хаанд эд зүйлс өгч буй зураг байсан. -Тугийн сүмийн хэдэн онд байгуулагдсан тухайд?

Б. Ринчен доктор “ Харин Зүүн Монгол дахь сүмийг Манжийн хаан Мозүнгийн эрх барьж байсан үе даруй Бүрэн засагчийн 3-р он 1866 онд Хэрлэний Барс хотын Чин ван Тогтохтөр Баян-Өрхөт гэдэг газар байгуулсан бөгөөд Чингисийн шүтээний сүм хэмээн нэрлэсэн байна.Тэрхүү шүтээний сүмд Чингис хаан хийгээд түүний их хатан, есөн өрлөг, жич Чингис хааны байлдан дагуулсан улс гүрний ахлагч нарын дүрийг бүтээсэн байрлуулсан байжээ. Энэхүү сүмүүд нь хэзээ ч хаана ч тодорхой тэмдэглэгдээгүй байсан. Тэдгээрт яг л манай зууны 30-аад оны үеийн Наянтай вангийн өвөг дээдсийнхээ дурсгалд зориулсан сүмээс олдсон шиг үнэт олдворууд болох эртний гар бичмэл, нум сум, хуяг дуулга, илд бамбай, туг дарцаг зэрэг олон тооны зүйлс хадгалагдаж байсан байна. ” гэсэн байдаг. Сүм дотор хатавчны зүүн урд буланд хар хувцастай данжаад хуй торго, орос хүн цай барьсан зогсож байдаг, сөгдөөд суучихсан баримал байдаг байсан гэдэг. Ер нь байлдааны хар сүлдэг харуулж мануулдаг сүм. Энэ нь бол мөргөлийн сүм биш. Тахилгын сүм. Одоо яг хундаам нь л байгаа юм. Сүмийг буулгасан хүнтэй өөрийн биеэр 1980 оны эхээр үүлзсэн. Даш гэдэг хүн байсан. Тэр хүн Дорнод аймгаас зүүн тийш 10-аад км-т амьдарч байсан даа. 70 гарсан ануухан хүн байсан. Тэр өөрөө буулгасан. Манай сумд багийн дарга байсан хүнээр нураалгасан. Тэр хүн сүмийн дотор байсан зүйлсийг буулсан газраа мэдэж байсан. Заагаад өгсөн ч мэднэ гэж байсан. Тэр баатрууд нь байшингийнх нь хаалга цонхоор гарахгүй байсан гэсэн. Тийм өндөр. Босоо хүнээс өндөр байсан гэсэн.. Тэгээд тэд нар бол хаалгаар нь багтахгүй байсан учир эвдэж гаргасан гэсэн. Та нар одоо тэрийг ухаад юм гарахгүй гэж байсан. Бүх баатар хүмүүсийг даавуу цаас хоёроор маяндаад хийчихсэн шүүмлүүд байсан байна лээ. Тэгээд гялгар төмөр, алт, мөнгөөр чимэглэсэн байсан гэж хэлж байсан. Тэгээд тэр тахилын сүмийн орой дээр хар сүлд нь байсан юм шиг байгаа юм. Хурал мурал хурдаггүй тугийг хамгаалсан л сүм байсан юм байна лээ. Одооны энэ 80,90 гарчихсан улсууд жаахан хүүхэд байхдаа хурга ишиг хариулж яваад ороход ч аав ээжтэйгээ ороход ч айж сүрдмээр ойртдоггүй байсан гэж ярьж байдаг.

-Тийм ээ, энэ хавийн Тугийг мэдэх настайчууд бараг нь л тэгж дурсаж байсан. Хөлөнбуйрын Даваа гуай тэгж хэлж байсан.

Яг Саруул гүний хошууны Тугийн хавьд тоглож өссөн хүн бол Булган сумын харъяат гэж явдаг юм одоо амьд бол Улаанбаатар хотод МУАЖ, Төрийн соёрхолт морин хуурч Жамъян гуай байна. Жамъян гуай бол яг нутгийн уугуул.

-Мөргөлийн сүм нь хаанаа байсан юм бэ? Шүтээний сүмээсээ баруун доод талд нь байсан юм уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Зүүн урд нь уу?

-Ямаршуу хийд байсан юм бэ? Нэг л дуган байсан уу?

Тэрийг одоо би сайн мэдэхгүй. Зүгээр очоод харахад урт ийм байшингийн туурь байгаа. Хойд талд нь ганжир байсан гэж байгаа. Тэрийг байна аа энэ мэддэг улсууд л тодорхой юм хэлнэ л дээ. Тэгэхээр энэ бол Булган сумд ч байдаг байлаа, Хөлөнбуйрт ч байдаг байлаа, Дорнод аймагт ч байдаг байлаа түүх дурсгалыг нь сэргээж аялал жуулчлал хөгжүүлэх том боломж байгаа юм. Ердөө голынхоо энд харагдаад байна. Киданы Хэрлэн Барс хот байна. Тугийн ойр орчмыг хамгаалалтанд аваагүйгээс болоод айл их нутаглаж байгалийн төрх нь алдагдаж байна. Тугийн хойно чинь зүйл зүйлийн шувуу чуулдаг нүүр байсан. Одоо гарахаа байж. Нэг ёсны Баянбүрд байсан. 70 хэд 80-аад оны үед чинь Оросууд хааяа ирж шувуу бууддаг байсан. Ширээгийн рашаан гэж гэдэс дотрын сайн рашаан байна. Тэгээд баруун тийшээ хэдхэн км давхиад Хөлөнбуйрын хүн чулуу байна. Тэндээсээ жаахан урагшлаад Тугтай харалдаа хоорондоо 5, 10 км зайтай Өлзийт уул байна. Энэ ууланд Чингисийн морины уяа, ор гээд байдаг. Ингээд энэ чинь аялал жуулчлалын том маршрут байна. Хэрлэн Барс нийслэл нь болох гэж байтал бар архираад бараас айгаад урагшаа нүүсэн гэсэн домог байдаг. Зарим нь болохлоо Бээжинг энд байгуулах гэж байхад нутгийнхан нь дургүйцэж бар болж дуугараад айгаад урагшаа буцсан гэж хэлдэг. Хэрлэн Барс хотыг улсын хамгаалалтанд авсан л юм гэсэн. Нэг хашаа барьсан. Өөр одоо юу хийх юм. Өвөл аймгийн Засаг даргатай уулзаад энэ тухай ярьж л байсан. УИХ-ын гишүүнтэй уулзаж ч бас ярьж л байсан. Зүгээр энэ сум оронгоос санал хүсэлт тавьж л байсан юм байна лээ. БХЯ-ны шугамаар сэргээж болох юм гэж яригдаж байгаа юм байж магадгүй юм байна лээ. Зөв санаа гэж бодож байгаа. Яагаад гэвэл Хар сүлд бол цэргийн сүлд. БХЯ Хар сүлдээ цэнгүүлнэ гэж Богд уулын ойролцоо уулын орой дээр гараад цэнгүүлчихээд ирлээ гэдэг. Тэгвэл одоо жинхэнэ цэнгүүлж байх газар нь хар сүлдний байсан газар эндээ цэнгүүлдэг болох хэрэгтэй гэж боддог. Энэ шүтээний сүмээ дагаад бий болсон байх. Хэдийд буй болсон юм. Сүүлд бий болсон байх. Хийд, хурлын газар байгаа.

-Энэ хийдийн тухай сонссон дуулсан зүйл?

Энэ тухай бол сууж хүрж байсан хүмүүс, тэднээс юм сонссон хүмүүс л юм хэлнэ. Та нар аймаг орохоороо Гүрбямбаа гэдэг хүнтэй уулзаарай. Бид хоёр хамтарч нэг юм гаргасан юм. Түүх судалдаг сонирхдог архивт их суусан. Надаас ч илүү олон хүнтэй уулзсан хүн байгаа.

-Өөр наад хоёр хийдийн тухай сонссон юм юу байна?

Ёстой мэдэхгүй. Зүгээр урд талын Бат уулын хийд бол гол хийд. Тэнд чинь цам, Майдар гардаг байсан гэж манай хадам хөгшин 86 хүрч ойчсон хүн ярьж байсан юм. Настайчуудаас, ах эгч, авга, нагац нь хэлмэгдэж байсан хүмүүс бас юм сонссон дуулсан байж болох юм. Би бол Тугийн сүмийн тухай л жаахан юм сонирхож цуглуулсан болохоос өөр цуглуулж сурвалжилсан зүйл байхгүй.